

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын танилцуулга

1. Нутаг дэвсгэрийн хэмжээ, Газарзүйн байршил, Онцлогийн талаар

Цэнхэрмандал сум нь хуучин Эх Дагинын отог гэж байсан бөгөөд 1925 онд Баянзүрх уулын хошууг шинээр байгуулагдахад Цэнхэрмандал сум гэж Наран, Бор хужирын хөлд эсгий гэртэй анх байгуулагджээ. Нийт 319.2 мянган /га/ газар нутагтай. Далайн түвшнээс дээш 1200-1500 м-т оршдог. Газар зүйн байршлын хувьд зүүн хойд талаараа Өмнөдэлгэр сум, зүүн урд талаараа Жаргалтхаан сум, өмнөд талаараа Дэлгэрхаан сум, баруун хойд талаараа Төв аймгийн Мөнгөнморьт сум, баруун талаараа Багануур дүүрэг Хэрлэн голоор хиллэж оршдог. Хангайн нутгийн төрөл бүрийн ан амьтан элбэгтэй аялал жуулчлал хөгжсөн, ашигт малтмалаар баялаг, уул уурхайн үйлдвэрлэл хөгжсөн нутаг юм. Тус сумын төв буюу Баянмод баг нь зүүн чиглэлийн мянганы зам дагуу Улаанбаатар хотоос 200 км, Чингис хотоос 150 км-т байдаг. Засаг захиргааны 4 багтай, Нугаар багийн төв сумын төвөөс 23 км, Хужхан багийн төв 17км, Согоот багийн төв 22 км-т тус тус оршдог. Нийт 765 өрх, 1871 хүн амтай, 0-17 хүртэл насны 561, 18-45 насны 951, 46-с дээш насны 359 хүн амьдардаг. Үүнээс 416 өрх малчин өрхтэй. Нийт 201667 толгой малтай. Мөн тус сумын нутагт оршдог “Хар зүрхний Хөх нуур” нь Тэмүжинг Чингис Хаан цолд өргөмжилсөн төдийгүй Цэнхэрийн гол нь “Сэнгүр горхи “ нэртэйгээр Монголын нууц товчоонд тэмдэглэгдэн үлдсэн түүх дурсгалт гол, нууртай юм.

Сумын газрын зураг



2. Хүн амын тоо, яс үндэс, соёл уламжлал, ёс заншилын талаарх

Багийн нэр	2014		2015 он		2016 он		Үүнээс	
	өрх	Хүн	өрх	Хүн	өрх	Хүн	Эр	Эм

		ам		ам		ам		
Хужхан	121	366	119	369	123	370	196	174
Нугаар	105	168	108	164	123	184	127	57
Согоот	181	390	180	374	197	397	239	158
Баянмод	321	922	324	923	322	920	472	448
Сумын дүн	728	1846	731	1830	765	1871	1034	837

Тус сумын 90-ээд % нь халх ястан, 10% хувь нь буриад болон дөрвөд сартуул гэх мэт ястангууд амьдардаг. Нүүдэлчин соёл уламжлалтай

3. Сумын брэнд бүтээгдэхүүн, түүний онцлогийн талаар /өнгөт зурагтай/

Дарийн Цэнд-аюушийн “Чацаргана”-ны аж ахуй 5 дахь жилдээ 300-500 кг чацаргана тариалж сумын иргэдийнхээ хэрэгцээг хангаж байна.




Адилбишийн Амаржаргалын 700 өндөглөгч тахиатай өрхийн аж ахуй нь сумын төвийн дэлгүүр, аж ахуй нэгжүүд болон огзомын амны бүх цайны газар, дэлгүүрүүдийг хэрэгцээг хангадаг.



4.Малын тоо, ангилал, сүүлийн 4 жилээр графикаар үзүүлсэн байх.

Сүүлийн 4 жилд тоологдсон багуудын малын тоо

Багууд	2013	2014	2015	2016	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
Хужхан	40108	43585	46827	52989	-	3746	3579	28484	17180
Нугаар	45005	50286	53329	59852	3	6639	3602	29463	20145
Согоот	53814	57123	59843	71865	3	4582	6046	37215	24019
Баянмод	10743	13140	14422	16784	-	969	2127	6561	7127
А/ газар	277		194	187	-	-	10	157	20
Сумын дүн	149947	164134	174615	201677	6	15936	15364	101880	68491



5.Амьтан, ургамлын аймаг, төрөл зүйл, ангиллын талаар /чанарын шаардлага хангасан өнгөт зурагтай/

Тус сумын нутагт буга, хандгай, баавгай, чоно, гахай, бор гөрөөс зэрэг ховор ан амьтад элбэг байдаг.

Тус сум нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Евроазийн хээрийн мужийн монгол дагуурын Өмнөд Хэнтийн районд хамрагдана.

Сумын ургамалшлын ерөнхий төрх нь харилцан адилгүй өндөртэй, бэсрэг уулс, жижиг толгод, нарийн ба өргөн хөндий хосолсон гадаргуугаар ойт хээрийн ба уулын хээрийн ургамалшлын янз бүрийн хувилбараар өөрчлөгдөн тархана. Бэсрэг уулс, Толгодын энгэр, оройгоор ботууль-алаг өвст, үетэн-алаг өвст, бүлгэмдэл ихээхэн тохиолдоно. Энд Ленийн ботууль, дааган сүүлт, биелэг өвст, шивээт хялгана, ганга, навтуул зэрэг зонхилсон ботууль-алаг өвст, ботууль-сөөгхөн, биелэг алаг өвст бэлчээр тархах бөгөөд уулсын зах сэжүүр, намхан толгодоор шивээт хялгана, хиаг, биелэг, ямаан шарилж, тарна зэрэг ургамал зонхилсон. Хялгана алаг өвст, хялгана хиагт, хиаг-хазаар өвс, алаг өвс-ботууль, хиагт бэлчээр тархана. Бэсрэг уулсын хоорондох өргөн хөндий болон нутгийн өмнөд хэсгээр хазаар өвс, хялгана, агь, шувуун хөл, нилээд хэдэн зүйлийн шарилж зэрэг ургамал зонхилсон хазаар-хялгана-агь, хялгана-алаг өвст хээрийн бэлчээр давамгайлдаг.

Голын хөндий хотгор газруудаар ширэг улалж, хиаг, улаан толгой, ахар сорт арвай зэрэг ургамал зонхилсон улалж үетэн, улалж алаг өвс, хиаг алаг өвст бэлчээр зонхилно.

Хужир марзат хотгор нуур тойрмын захаар буурцаганат, дэрст бэлчээр элбэг ургана.

Хялгана өвс



Хазаар өвс



Сөөг өвс



Дэрст өвс



Бор гөрөөс



Хандгай



6.Түүхийн дурсгалт газруудын мэдээлэл /өнгөт зурагтай/

1.1189 онд Тэмүжинг Чингис хаан цолд өргөмжилсөн “Хар зүрхний хөх нуур”



2.Согоот баг “Чингисийн гурван тулга”



3.Хуурайн амны “Хадны сүг зураг”



4. “Бургастайн бичигт хад”



Согоот баг “Согтуугийн хурлын туурь”



Согоот баг “Уртын амны тахилын байгууламж”



Согоот баг “Уртын амны адгийн дурсгал”



7. Байгалийн баялаг, ашигт малтмалын орд газрын тухай

- Баянмод багийн “Цагаан тугалага”-ийн орд
- Баянцогтгийн “Гянтболд” шороон орд
- Ар хадагтайн “Шороон алт”-ны орд
- “Согоот” багийн Юдэг гэдэг газар “Гянтболд”-ын орд

8.Өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд үйлдвэрлэлийн талаар /өнгөт зурагтай/

Одоогоор үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа жижиг дунд үйлдвэрлэлүүд:

Б.Ганзоригийн “Бор морин дэл” талхны цех



Г.Оюунцэцэгийн Оёдлын цех



О.Сайнхүү, Я.Амгаланбаатар нарын “Дугуй засвар”-ын үйлчилгээ сумын төв болон Огзомын амны зам дагуу байрлах дугуй засварын үйлчилгээгээ тогтмол иргэдэд хүрч ажиллаж байна.



-Ц.Амгалангийн “Нэхий боловсруулах” аж ахуй нь үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна.



-17 иргэн , нэг хоршоо төмс, хүнсний ногоо тариалдаг



-Малчид Намрын ногоон өдрүүд, Цагаан сар цагаан идээ үзэсгэлэн худалдаанд идэвхитэй оролцдог



- Гар урлал, оёдол эсгүүр эрхэлдэг иргэд цөөнгүй. Гар урлалын чиглэлээр С.Энхтүвшин нь Аймагтаа удаа дараа шилдэг бүтээлүүдээрээ гар урлалын төрлөөрөө тэргүүн байр эзэлж одоог хүртэл уг бүтээлээрээ үйл ажиллагаагаа явуулсаар байна.



9.Цаашид хөгжүүлэх боломжтой үйлдвэрлэл үйлчилгээ, сумын хэтийн хөгжлийн төлөвийн талаарх мэдээлэл

1. Тус сум нь ойт хээрийн бүсэд хамрагддаг учир **“Зөгийн аж ахуйг үржүүлэх”** боломжтой.
2. Тус сум нь Улаанбаатар Хэнтий аймгийн голд орших бөгөөд зах зээлд ойрхон мянганы зам дагуу учир **“Өвлийн хүлэмжээр хүнсний нарийн ногоо тарих”** цаашид борлуулах боломжтой.
3. Сүүлийн жилүүдэд мал их хэмжээгээр өсч байгаатай холбогдон суманд **“Арьс шир боловсруулах”, “Мах боловсруулах”** үйлдвэр барьж байгуулах боломжтой.
4. Төв суурин газрууд ойрхон мөн зах зээлд ойрхон учир **“Нийтийн ахуйн үйлчилгээ”-г** цаашид хөгжүүлэх боломжтой.
5. **Гар аргаар бэлэг дурсгалын зүйл** хийдэг олон чадварлаг багш, иргэд байгаатай холбогдон сумандаа уг чиглэлээр бэлэг дурсгалын зүйл хийж олон нийтэд түгээх цаашид аймаг нийслэлд түгээн дэлгэрүүлэх боломжтой.

Боловсруулсан:

Нийгмийн бодлогын түшмэл Б.Адьяахүү

Хянасан: Засаг даргын орлогч Б.Болорцэцэг